

газраас эхлэн Самарканд, Бухар хүрдэг. Ордоо Алимын хост барьжээ. Өгөөдэйн хувьчилж авсан нутаг Эмил болон Ховог сайр орчим байж мал аж ахуйг хөгжүүлэхэд маш тохиромжтой газар байсан” гэж тэмдэглэсэн¹. Энэ тэмдэглэлээс бид тухайн цагийн баруун хязгаарын монголчуудын аж амьдралын байдлыг тодорхой хэмжээгээр ойлгож болох юм. Баруун хязгаарыг захиран эзлэхээр нүүн очсон барулас аймаг, хонгирад аймаг болон доголонт аймгийнхан бүр ч монгол уламжлалт зан үйлээ гүн хадгалсан байсан тул нэлээд урт хугацааны турш өөрийн ёс заншлаа баримтлан хадгалсаар байжээ. Зарим нэг хэсэг нь Мин улсын эхэн болтол бүр нүүдэл малжилын амьдралаа эрхэлсээр байжээ. Мин улсын эхний үед баруун хязгаарт томилогдож хүрсэн Чэн Чэн «Баруун хязгаарын олон улсын түүх» хэмээх номдоо Бишбалагын монголчуудын оршин амьдарч байгаа байдлыг тэмдэглэхдээ: “Хот хүрээ гэр байшин гэж байхгүй, цаг агаарын байдлыг үндэслэж өвс бэлчээрийн сорыг даган нүүдэллэж үхэр адуу маллан өдөр хоногийг нөхцөөдөг. Нүүдэллэн буйршсан газартаа эсгий гэр босгож дотор нь эсгий дэвсэж дээр нь хонож хэвтэх буюу суудаг”²³. Ийнхүү хувцас хунар засал чимэглэл нь ч уламжлалт маягаар байжээ. Тухайн цагт монгол нутгаар жуулчилж байгаа европын жуулчин Плано Карпини, Рубрук монгол хүмүүсийн өмсгөл зүүлтийг ингэж ярьсан байдаг: “Монголчууд урт тэрлэг өмсөх дуртай, эмэгтэй эрэгтэйн тэрлэг ихэнхдээ ижил байдаг. Энгэр нь баруун талдаа өөд хандсан байдаг бөгөөд дөрвөлжин захтай, зүүн талд нь нэг товч, баруун талд нь гурван товчтой, зүүн талд нь бүсэлхээс шилбэ хүртэл оноотой байдаг. Тэрлэгээ голдуу торго дурдан, хөвөн даавуу ба арьсаар хийдэг”⁴.

Толгойн засал нь мөн л уламжлалт толгойн засал. Хөхүүл малгай, зүүгээ /засал/ шигтгээрийн зүйлүүдээр голлож байв. Нэлээд сүүлч үе зүүн Цагаадай хаант улсын үед хүрч ирээд эндэх монголчууд алгуур аажмаар исламжиж тэдний толгойн засалд ч хувиралт гарсан байдаг. Тухайлбал цагаан бүс буюу торгоор толгой, хүзүүгээ ороох болжээ. Идээ ундааны байдлыг авч хэлбэл эндэх монголчууд нэлээд урт хугацаагаар өөрийн уламжлалт заншлаа хадгалсаар иржээ. Бодитойгоор хэлбэл, тэд мөн мах цагаан идээгээр гол хоолоо болгодог. Баруун хязгаарт нүүдэллэн нутагласан Доголонт аймгийн монголчууд “бид нар зэрлэг араатан жигүүртний махыг иддэг юм” гэж хэлдэг⁵. Энэхүү заншил нь монгол хүний уламжлалт ан агнуурын амьдралтай нягт холбоотой гэдгийг нэг алхам нотолж өгсөн байна.

Ураг гэр бүлийн хувьд баруун хязгаар дахь монголчууд уугуул зан заншлаа баримтлалсаар иржээ. Гэр бүл доторх ажил төрөл эрэгтэй, эмэгтэйгийн хуваарьтай. Эрэгтэй нь голдуу ан агнуур, дайн байлдаанд оролцох зэрэг хатуу хүнд ажлыг хийж эмэгтэйчүүд голчлон гэр зуураа мал ахуйгаа тохируулж, сүү сааль боловсруулах, дээл гутал, хувцас хунараа урлан зохироох ажил төрлийг хийдэг байжээ. Рубрук жуулчлалын тэмдэглэлдээ “Дайны үед эмэгтэйчүүд даган мордож ачаа үүрэг хувцас хунар зэрэг үлдэж хоцорсон зүйлсийг хамгаалдаг. Энгийн үед тэд нар үнээ саах, сааль боловсруулах, арьс хөрс, ноос ноолуур зэргийг элдэж боловсруулж оёх зэрэг ажлуудыг гүйцэтгэдэг” гэжээ⁶. Юань улсын үед нүүдэллэж ирсэн баруун хязгаарын монголчууд уламжлалт ёсоор өөр овог аймгаас эхнэр буулгах буюу булааж авдаг байсан бөгөөд нэг эрэгтэй хэдэн ч эхнэр буулгаж болдог байв. Энэ нь тухайн үед эрэгтэй хүмүүс дайн дажинд яваад хорогдож үрэгдээд хүн амын хувьд эмэгтэйчүүдээс цөөн байсантай холбоотой юм. Тэрчлэн ах нь нас барвал дүү нь бэргэнээ авч суух уламжлалт заншлыг хадгалж байв. Жишээлбэл зүүн Цагаадай хаант улсын Юнэс хаан үхээд дүү Мирзан Махаму Хайдар монгол хүний заншлаар бэргэнээ эхнэр болгон авчээ.⁷ Сүүлдээ баруун хязгаарын монголчууд исламжихыг дагалдан энэ заншил алгуураар гээгдсэн билээ.

2. Уйгарчууд. Юан улсын үед уйгарчууд голдуу Бишбалаг (одоогийн Жимсайр) Хэр хажуу (одоогийн Турпань) зэрэг газруудаар аж төрөн амьдарч

байжээ. Тухайн үед бичигдсэн зарим түүхэн материалд бас чүйшэн (одоогийн куча), кашгар, хотан, хамил зэрэг хүмүүс тэмдэглэгдэж байдаг. Эдгээр нь монголчуудыг нэгтгэн захирч исламын соёлоор нягтран уялдаж Мин улсын сүүлч үе болоход алгуур аажмаар уйгар хэмээх угсаатны бүрэлдэхүүн болжээ.

Уйгарчууд говийн ард монголын өндөрлөгт байх үедээ нүүдлийн мал аж ахуй эрхэлж байсан билээ. Он тооллын 840 онд уйгарын хаант улсын сүйрэлийн улмаас уйгарчууд задран сарниж ихээхэн хэсэг нь баруун хязгаарт нүүдэллэн ирж аж төрөн амьдарсан байв. Юан улсын үед уйгарчууд хагас тариалах, хагас малжих аж ахуй эрхэлж байжээ. Энэ нь нэг талаар тус газар орны байгаль орчин ахуйтай зохицохыг анхаарснаар барахгүй нөгөө талаар тухайн үед нүүдэллэн ирж захиран суусан монгол хүмүүсийн нөлөөг хүртсэн юм. Энэ үед Тэнгэр уулын араархи уйгар хүмүүн мал аж ахуйг нэлээд хэмжээгээр чухалчилж ан агнуурыг ч нэгэн хэмжээгээр хийж байсан бол харин Тэнгэр уулын өврөөрхи уйгар хүмүүс тариалан хийж гуа жимс тарихыг чухалчилж байжээ.

Уйгарын гар үйлдвэр нэлээд хөгжжээ. Жишээлбэл Бишбалагт төмрийг хайлуулж боловсруулах газартай байж. Түүнчлэн уйгарчуудын нэхмэлийн мэргэжил нэлээд өндөр шатанд хүрсэн байдаг. Тухайлбал Жей Юаны 13-р онд (1276 онд) Юан улсаас Бишбалагт дарханы товчоо байгуулж “Нашаш торгыг нэхэн үйлдүүлэхийг тусгай хамааруулж байжээ”⁸. Энэхүү байдлыг бид Турпаниас олдсон уйгарын нийгэм амьдралыг харуулсан түүхэн дурсгалт бичгүүдэд “хөвөн” хэмээх үсэг бичиг байхаар барахгүй “хөвөн бөс”, “олсон бөс” зэрэг үг өгүүлбэрийг тэмдэглэж байх бөгөөд арилжааны байдлыг ч тэмдэглэсэн агуулга байдаг⁹. Энэ үед уйгарын үзмийн дарс хийх мэргэжил тун өндөр байв. Юан улсын ордны бичиг «Ундаа хоолны чухал зүйл» хэмээх номд Дайду хотын үзмийн дарс “баруун газрынх байдаг, хар хажуугийнх, пин-ян-гийнх, тай-юаных байдаг, гэхдээ үнэр амтны талаар хар хажуугийнх хамгийн сайн гэжээ”¹⁰. Түүнчлэн эрдэмтдээс арзыг баруун хязгаараас дотор газар уламжилж ирсэн бөгөөд дотор газрынхан жимсний дарс нэрэх аргаас будаагаар архи нэрэх аргыг олж мэджээ гэж судалж гаргасан байна¹¹. Үүнээс бид баруун хязгаарын архи дарс нэрэх мэргэжил хятадын Жунь-Юан орны архи нэрэх мэргэжлийг хэр зэрэг нөлөөлж байсныг мэдэж болох юм.

Уйгарчууд арилжаа наймаа хийхдээ тун сурамгай юм. Тэд нар хятад орноос Дундад Ази Европт хүрэх торгон замын багалзуур хоолой дээр оршин суурьшиж байдаг тул аль эртээс арилжаа наймааны сонирхолтой болжээ. Хувилай хааны үед Дундад улсад айлчлалаар ирсэн Марко Поло Тэнгэр уулын өврөөр өнгөрөхөд Кашгарын ард “арилжаалах буюу гар бүтээгдэхүүнээр аж төрж” байх бөгөөд тэндэх арилжаачин тус газрынхаа бүтээгдэхүүнийг “дэлхийн олон газарт борлуулж буй” Хотаны ард ч мөн “арилжаа буюу гар бүтээгдэхүүнээ түшин амьдардаг” гэж жуулчлалын тэмдэглэлдээ бичсэн байдаг¹². Энэхүү тэмдэглэлээс бид уйгарчуудын арилжаа, гар үйлдвэрлэлдээ гарамгай байсан гэдгийг ойлгож болно.

Бид уйгарчуудын хувцас хунар, засал чимэглэл ямар байсан гэдгийг мэдэхэд бэрхшээлтэй байсан байна. Учир нь энэ тухай түүхэн сурвалж туйлаар чухал байна. Бид зөвхөн хэсэг бусад ханын зураг зэргээс бага сага мэдэж болох төлөвтэй байгаа. Орчин үед эртний судлагч нараас Бишбалаг хотны уйгар сүмийн ором үлдэгдлээс нэлээд арвин уйгар сүсэгтний толгойн зургийг олж авсан байдаг. Тэдгээр зургуудад уйгарын Идаху¹³ толгойдоо өндөр гэгч туйрын хэлбэртэй малгай зүүж, малгайгаас нь хоёр зүсэм улаан өнгөтэй торгийг баруун мөрөн дээрээ унжуулсан байдаг. Хувцас нь дугуй захтай, энгэр нь нэлэнхийдээ уужуу хүрэм байв. Хувцасны өнгө нь шар өнгөтэй. Судалгааны үндэслэлүүд Юан улсын үед уйгарын дээд давхраатны хувцасны өнгө нь шар байсан гэжээ. Энэ нь уйгарчууд улаасна бурхан шашин шүтэж байсантай холбоотой гэж ханын зураг дахь үзэгдэл хатан толгойдоо галбинга малгай зүүж магнай дээр нь өндөр гэгч заслыг унжуулж нэг зүсэм улаан хүрэн торгыг малгайгаас нь газар тултал унжуулсан байв. Тэр биедээ уужим гэгч элсэн өнгөтэй улаан өнгийн мушгиур хуар сийлсэн

захтай хувцсыг өмссөн байв. Ийм маягийн зургийг Дүн-хуан-гийн ханын зурагт бас олж харсан юм. Энэ маягийн хувцас болж умардын нүүдэлчин овог аймгуудын хатад бэргэдийн гоёлол заслалын хувцас байж нэлээд урт удаан түүхтэй¹⁴.

Хоол ундааны хувьд уйгарчууд баруунш нүүдэлж нутагласны хойно нэлээд удаан хугацаагаар өөрийн уламжлалт нүүдэл малжилын амьдралаа хийж байжээ. Сүн улсын Ван-Ян-Дэ хэмээгч хүн баруун хязгаараар явж байхдаа уйгар хүний "харваж намнахдаа бахтай", "эрхэмтэн хүмүүс нь адууны мах идэж, харц ард нь хонь, ямааны мах буюу жигүүртэн шувууны махыг иддэг" байсныг харсан байжээ. Үүнээс бид амьдралын зан дадхаал нь нэг үндэстний соёл хэр зэрэг байр суурьтай байгааг мэдэж болох билээ. Гэтэл тэд нар он тооллын 9-р зуунаас 14-15-р зуун хүртэл хэдэн зуун жилийн турш баруун хязгаарын олон арван угсаа үндэстнүүдтэй холилдон суухын зэрэгцээ нөлөө хувирал хүртэж идээ ундааны зүйлд нь нэлээд хувирал гарсан байна. Жунь-Юан орны бумбын сургаалтан Чю-Чу-Жиди баруун Шаялинд Хар хажуу, Бишбалаг зэрэг уйгар хүмүүсийн төвлөрөн суугаа газруудаар өнгөрөх үед уйгар хүмүүсийн "алим жимс, боорцог, сонгино, үзмийн дарсаар хооллож" байхыг олж харсан байв. Мөн Марко Пологийн аяллын тэмдэглэлд ч энэ талын агуулга тусгагдсан байдаг.

Орон сууцын талаар уйгарчууд уулаасаа нэлээд их хувиралт үүссэн байна. Жишээлбэл тэд шавраар барьсан тэгш оройтой байшинд суудаг. Ийм байшин нэг талаар өвөл, хаврын цас шуурганаас айхгүй мөртлөө нөгөө талаар зуны улирлын аагим халуунд ч сэрүүн тохилог байдаг юм байна. Одоо ч иймэрхүү байшинд сууж байдаг. Энэ байшингийн онцлог нь гэвэл хэрэм нь зузаан, гэрийн саравч нь өргөн, гэрийн орой дээр нь яг монгол гэрийн тооно шиг жаахан тоонотой. Энэхүү гэрийн орой дээрх цонх нь монгол гэрийн тооныг санагдуулах юм. Тэд нар эсгий туургынхаа тооныг нь үлдээн хоцроосон юм билүү гэмээр.

Ураг гэр бүлийн хувьд уйгарчууд нэлээд чанга журам ёстой байдаг ажээ. Марко Поло тэмдэглэлдээ "нэгэнтээ хуримласан хойно эрэгтэй нь гэрээсээ салж яваад хорь хоногийг хэтэрвэл гэртээ хоцорсон эмэгтэй нь дуртай бол өөр хүнтэй суух эрхтэй. Эрэгтэй нь ийм эрх чөлөөтэй"¹⁵ гэжээ. Гэр бүл дотор сөн ч эрэгтэй нь эрх сүртэй байж, эмэгтэйчүүдийн байр суурь дорой буурай байдаг. Эрэгтэй нь аж ахуйн нөхцөлтэй бол хэдэн ч эхнэр авч болдог. Эхнэр хүнд гэрийн эд хөрөнгөө өмчлөх эрхтэй. Оршуулах ёс нь чандрыг нь шатааж булшлах буюу шууд авсанд хийж булшлах хоёр янзтай байжээ. Рубрук аяллын тэмдэглэлдээ "уйгарчууд хуучин заншлаа баримталж үхэгсдээ шатаагаад чандрыг нь алтан суварганы орой дээр оршуулдаг байв"¹⁶ гэжээ. Энэхүү заншил нь нэг талаар эртний турк үндэстний уламжлалт заншлыг хадгалж байх бөгөөд нөгөө талаар бурхан шашныг шүтэж байсантай холбоотой гэж үзжээ. Авсанд хийж булшлах ёс нь тухайн цагт нэлээд эрх сүртэй хүн л хийж чаддаг зүйл байжээ¹⁷. Ингэж оршуулахад газар авч онгон гаргадаг тул эрхбиш баян эрхэм хүн л биелүүлж чаддаг байна.

Уйгар хүн тахилга цээрийг ч ихээр хүндэтгэдэг. Уйгарчууд уулын сахиус, борооны сахиус зэргийг тахидаг байснаар барахгүй өвгөд дээдсээ ч тахидаг заншилтай байжээ. Рубрук уйгар газраар явж байхдаа уйгарчууд дээдсийн хөрөгөө шуумал хийж тахиж байсныг олж харсан байв.

Юан улсын үед монголд ноёрхогч "олон шашныг зэргээр байлгах" төрийн бодлогыг хэрэгжүүлж байснаар уйгарчууд тухайн үед бурхан шашин, нестрос шашин, ислам шашин, бумбын шашин зэрэг олон шашин шүтэж байжээ. Харин Мин улс даруй зүүн цагаадайн хаант улсын үед ороод нийтээрээ исламын шашин шүтэх болсон юм.

3. Харлаг. Харлаг бол Юан улсын үед баруун хязгаар оронд нэлээд хөгжилтэй гэгдэх нүүдэлчин аймаг байсан юм. Монголын хаант улс ба Юан улсаас өмнө харлаг нь урьд хожид Хар хаант улс¹⁸, Баруун ляо улс зэрэгт харъяалагдаж байв. XIII зууны эхэн үеэр хөрш зэргэлдээ байсан уйгарчуудын нөлөөллөөр Хаяалигийн харлаг ахлагч Арслан хаан болон Алимьн харлаг ахлагч Вачир хаан

хоёр Чингисийг даган ирж¹⁹ тэгснээр монгол хаан өөрийн ордны хүүхнээ Арслан хаанд гэргий болгож тохинуулсан байна²⁰. Мөн Алимын Вачир хаан үхсний хойно түүний хөвүүн Шигнагидэжин эцгийнхаа орыг залгамжлан тус газрын цэрэг засгийн явдлыг зарлигаар хамаарч Чингисийн хайрыг олсон бөгөөд Чингисийн ууган хөвүүн Зүчийн хүүхэнтэй хуримласан байжээ. Монголчууд баруунш дайлах ба сүүлээр хятад орныг нэгтгэх үед бүр харлагчууд хүчирхэгжиж байжээ. Юаны үед харлагчууд Цагаадайн хаант улсын иргэд болж алгуур аажмаар баруун хязгаарын бусад үндэстнүүдэд хайлагдан шингэжээ. «Дэлхийн хил хязгаарын түүх» хэмээх номонд харлаг хүнийг "нэг хэсэг нь анчин, нэг хэсэг нь тариачин, бас нэг хэсэг нь малчин, тэдний эд хөрөнгө бол адуу хонь болон элдэв арьс ноос юм. Тэд нар эрэлхэг үндэстэн болох бөгөөд түрэмгийлэгч зантай" гэж тэмдэглэсэн байдаг. Энэ тэмдэглэлээс бид харлагчуудын аж ахуй амьдралыг нэгэн хэмжээгээр ойлгож болох юм.

Харлаг нь исламын шашныг шүтэхийн зэрэгцээ өөр шашныг бас шүтдэг. Энэ нь тухайн үед баруун хязгаарын үндэстнүүд олон зүйлийн шашныг зэргээр шүтэж байсантай нягт холбоотой. Гэхдээ тэд нарын олонхи нь исламын шашныг шүтдэг мөртлөө исламын шашинд баруун хязгаарын бусад үндэстнээс бүр эрт орсон гэдгийг тэмдэглэх ёстой. Юан улсын үед харлагчуудын дотроос нэлээд олон шалгарсан улс төрч, зохиолч, шүлэгчин гарсан юм. Тухайлбал Теванчи, Милихужи, Шажюан, Ехандэжин, халадэй, Мама, Хадан, Дашман, Чишү, Бөтөмөр, Хоттөмөр, Баян гэх мэт.

4. Сартуул. Юан улсын үед исламын шашныг шүтдэг дундад азийн турк төрөл хэлтний олон үндэстэн тухайлбал перс, араб хүн хийгээд тэдний хойч үеийхнийг сартуул гэдэг. Тухайн үеийн сартуулын тархац тун өргөн. Тиймээс түүхэн бичигт "Юаны үеийн сартуул газар бүхэнд баймуй" гэдэг хэллэг гарсан билээ. Баруун хязгаарт аж төрөн амьдарч байсан сартуулууд олонхидоо бусад үндэстэн угсаатнуудтай холилдон суурьшиж байдаг. Тэгэхээр зарим хятад түүхэн сурвалж болон исламын түүхэн сурвалжид ямагт сартуул ба уйгарыг хутган холилдуулж байгаа үзэгдэл гардаг буюу "баруун хязгаарын хүн" гэдгээр орлуулагдаж байжээ.

Сартуул хүмүүсийн аж төрж амьдрах хэлбэр нь их төлөв уйгартай адил "бүр л тариалах буюу нэхмэлдээ сайн, байлдаж тэмцэхдээ барагтай" гэж түүхэн сурвалжид тэмдэглэсэн байдаг. Харин сартуул хүний өмсгөл засал нь тус газрын уйгар хүнээс тун өөр байж "эрэгтэй нь үсээ хусаж, жижиг тумлай өмсдөг, эмэгтэйчүүд нь цагаан бөсөөр толгойгоо ороодог"²¹ бас «Дөрвөн харийн өргөн тэмдэглэл»-д "эмэгтэй, эрэгтэйгүй урт цагаан хүрэм өмсөж, эрэгтэй нь үсээ хусаж, бүсээр толгойгоо ороодог. Эмэгтэй нь гэзгээ гөрж шууж боодог бөгөөд нүүрээ бүтээж үзүүлдэггүй" гэж тэмдэглэсэн буй. Үүнээс бид тэд нарын өмсөж зүүх нь яг л Дундад Ази, Арабын исламын шашнууд шиг гэдгийг олж харна.

5. Хятад. Хятад бол мөн л баруун хязгаарын чөлээд эртний иргэд болно. Аль эрт баруун Хан улсын үед баруун хязгаарт нүүн орж аж төрөн амьдарч эхэлсэн юм. Юан улсын үед монголчууд баруун хязгаарт нүүдэллэн орохыг дагалдан хамагдан орсон буюу баруунш дайлах үест "алтан ургийн" хэмээн "хөрөнгө буюу хуараар" аваачсан хятад хүмүүс ч нэлээд олон бий. Зарим нь бас цэргийн албанд татагдсан буюу тариалуулахаар шилжүүлэн аваачигдсан хятад хүмүүс тун арвин байгаа билээ. Тэд бүгдээрээ баруун хязгаарыг сахин хамгаалж б.т.ээ байгуулахад хүч үйлсээ өргөсөн юм.

Эрт үед нүүн очсон хятад хүмүүс олон зуун жилийн турш тухайн газрын эрдэмтэн ардтай харилцан амьдарсны улмаас тэндхийн зан заншилд ихээр нөлөөлөгдөж тэндхийн аж ахуйн арга барилыг шингээн авсан байна. «Цанчун бичиг» - баруунш зорчсон тэмдэглэл»-д "Чиючужи Бишбалагт хүрэх үед тэндэх ван эрдэмтэн цэрэг харц ард, лам хуврагууд зуугаад хүмүүс хүрэлцэн ирж угтав. Лам нар бусад эрдэмтэн хувцас өмссөн нь хуврагуудын малгай засал нь Жун-Юан орноос огт өөр

байв” гэж тэмдэглэсэн байдаг²². Энэ тэмдэглэлээс тэдгээр эрт үед нүүн очсон хятад хүмүүсийн хувиралтыг олж харна. Тэд нар ингэж хувирч байснаар барахгүй зарим нь тухайн газрын суурьшмал ардад уусан тэдний нэг бүрэлдэхүүн болсон нь ч зөндөө байгаа билээ.

6. Киргиз. Киргиз бол мөн л нэлээд эрт баруун хязгаарт суусан эртний нүүдэлчин угсаатан юм. Тэдний амьдралын зан дадхаал бараг монголчуудтай адил. Бүр л өвс бэлчээрийн сайныг даган нүүдэллэн малждаг угсаатан билээ. Тэд эрт үед Енесей мөрний дээд урсгалын сав газруудаар амьдарч байжээ. XIII зууны 20-иод онд Чингис хаан тэдний төвлөрөн суугаа нутаг Чэнчэнжү-г эзлэн авчээ. Хувилай Аригбөхийн самуурлыг дарсны дараа Чэнчэнжүг өөрийн хараандаа оруулан²³ Жү-Юаны 7-р он (1270 он), 17-р онд (1280 он) Лиу-ху-лиг киргиз зэрэг таван аймгийн туслагч даргаар томилов²⁴. Жи-Юаны 28-р он (1291 он)-д Юан улс киргизээс ойрад хүрэх зам өртөө байгуулав²⁵. 30 онд (1293) монгол цэргийн жанжин Тогтох цэрэг гарган Чэнчэн голыг эргүүлэн авч киргиз зэрэг таван аймгийг хамаарсан байна²⁶. Ингээд юан улсаас киргиз аймгийг бүрмөсөн эзлэн захирч чадсан байна.

Монголчууд хийгээд түүний хойч үеийнхэн баруун хязгаар орны үндэстний бүтэц бүрэлдэхүүнд өгсөн нөлөө

Монголчууд баруун хязгаарыг нэгтгэн захирснаар баруун хязгаарын өөр хоорондоо үл хамаарах жижиг жижиг улсуудын хил хязгаарыг эвдэж нэгдсэн төрийн захиргаан доорхи газар орны засаг захиргаа болгосон байна. Бодитойгоор хэлбэл, Гаочань уйгар газрынхан Ядху сайн дураараа Чингис хаанд дагаар орсноор өөрийгөө эзэн мэдэхээс гадна баруун хязгаарын эл газар нь бүр монгол хаад ноёдын харъяат газар болжээ. Тухайлбал, уулын баруун Ляо улсын нутаг байсан Тэнгэр уулын ар өврийн тал газрууд Гаочань болон Долоон мөрний хоорондох газар Цагаадайн харъяат нутаг болов. Найманы харъяат байсан Имэлиэс хойш Эрчис мөрөн болон Алтай уулын хэсэг газар Өгөөдэйн харъяат нутаг болов. Хотан, Кашгар, Хаяали болон дундад азийн Самарканд, Бухала зэрэг тариалангийн балгас хөдөөд их хаан тусгай хүн томилон хамааруулж төвөөс шууд захирах болгов. Монголын хаант улс болон Юан улсаас Тэнгэр уулын ар өврийн эл газрыг ингэж нэгтгэн захирснаар тус газрын аж ахуйн хөгжилтийг ахиулан түргэтгэснээр үл барам овог аймаг болон угсаатнуудын хоорондох харилцаа холбоо, хамтраал, нэгдлийг ахиулж баруун хязгаарын хүн амын бүтэц бүрэлдэхүүнд лут хувиралт гаргасан байна. Тухайлбал,

1. Монгол хаант улс баруун хязгаарыг нэгтгэн захирахыг дагалдан монголын хэсэг хаад язгууртад болон харъяат ард Тэнгэр уулын ар өврийн олон газарт нүүдэллэн нутаглаж олон үндэстний өлгий болсон энэ газарт бас нэгэн шинэ хүн хүч нэмэрлэсэн байна.

2. Монголчууд Тэнгэр уулын ар өврийг нэгтгэж удаан жилийн турш хэсэглэн эзэрхэж байсан байдлыг эцэслүүлж тухайн орны турк хэлтний эл овог аймгуудын хоорондох харилцаа холбоо нэгдэлд боломжийн нөхцлийг бүрэлдүүлэн өгсөн юм. Уйгарчууд голдуу Бишбалаг, Хар хажуу зэрэг газруудад аж төрөн амьдарч байжээ. Юан улсын эхэн үед тэд нар бусад төрөл хэлтнүүд (Хаяали болон Алимьн харлаг хүн) тэрчлэн Тэнгэр уулын өвөр газруудын ногоон бүрдэд газар тариалан эрхэлж амьдардаг Кашгар, Хотан болон Тэнгэр уулын зүүн биеэр байгаа Хамил хийгээд захиран суугч монголчуудтай аж ахуй ба соёлын талаар өргөн хэмжээгээр чөлөөтэй холбоо барьж чадах болсноор туркжсэн, исламжсан орчин үеийн уйгар үндэстний бүрэлдэн тогтох хаалгыг нээн өгч эртний баруун хязгаарын үндэстний бүтцэд урьд өмнө нь гараагүй хувиралт үүсгэсэн байна.

3. Юан улсын дунд үе онцгойлон баруун хойдын ноёдуудын самуурлыг түвшитгэсний дараа Юан улсаас баруун хойд хил хязгаар орныг захирах чадвар суларч эхлэв. Жэ-да-гийн хоёрдугаар он (1309)-д Өгөөдэйн хаант улс мөхөгдөж түүний ихэнх хэсэг газар нутаг нь Цагаадай хаант улсын хараанд орж Цагаадай

хаант улсын сүр хүч нь ихээр нэмэгдсэн байна. Эсэнбуха хааны үед Цагаадай хаант улсын төв баруунш нүүж Цагаадайн хойчис суурьшин газар тариалан эрхлэн амьдрах болсон. Мөн энэ үеэр баруун хязгаарын Хар хажуу, Бишбалаг, Хотан зэрэг их хотууд бүр Цагаадай хаант улсын хараанд орж Юан улсаас зөвхөн Цагаадай улсыг аргадан татах аргаар энэхүү өргөн уудам газар орныг зэмшиж байжээ²⁷. XVI зууны дунд үеэр Цагаадай хаант улсын дотоодод түшмэлүүд хийгээд Алтан урагтны хоорондох зөрчил ширүүсч 1347 онд Хажин хаан доорхи түшмэлдээ алагдаж хаант улс зүүн баруун хоёр хэсэг болон задарсан билээ. Баруун хэсгийн эрх нь түшмэл Хаж хааны гарт орж зүүн хэсгийн эрх нь мөн хүчирхэг их монголын Доголонт аймгийн гарт байжээ. Доголонт аймгийн түшмэл өөрийн аймгийнхаа эрх ашгийг бодолцож Цагаадайн хойч Доголон Төмөрийг хаан өргөмжилж Зүүн Цагаадай хаант улсыг байгуулаад Тэнгэр уулын ар өврийг эзлэн захирсан байна. Доголон Төмөр өнгөрсөн хаант улсын сүр хүчнийг дахин мандуулахын төлөө нэг талаар цэрэг, морь бэлтгэн нөгөө талаар цагийн байдалд тохируулан 16 түмэн монголчуудаа дагуулан исламын шашныг шүтсэнээр тухайн орны ард иргэдийн хүрээллийг олж хүчээ өргөтгөснөөр үл барам монгол эрх баригчид суурьшмал болж шилжин хувирахын анхны алхмыг хийсэн байна²⁸. Энэ цагаас эхлэн Цагаадай хаант улсын хаад ноёд идэг идгээр исламжсанаар барахгүй өөрийн эрх ашгаа бататгахын тулд исламын шашныг өөрийн харъяат монгол иргэд хийгээд бусад үндэстэн овог аймгуудын дунд ихээр сурталчлан хүчтэйгээр дэлгэрүүлсэн байна.

4. Исламын шашин нь Тэнгэр уулын араархи өргөн уудам уйгар нутгуудаар дэлгэрэн эцэстээ бүх баруун хязгаарын бусад шашныг түлхэн зайлуулаад голлох байранд орсон явдал нь монгол язгууртан ноёд түшмэдийн исламжсантай нягт холбоотой билээ. Олны мэдээжээр Цагаадай хаант улсын үед Долоон мөрний сав газруудад шилжин суурьшсан монгол хаад жишээлбэл Бараа, Бармашир, Хазан зэрэг хаад исламын шашинд орж тэдний нөлөөллөөр дундад Азийн тариалах оронд орж суурьшсан их тооны монголчууд исламын шашныг сүсэглэн шүтсэн байдаг. Үүнээс болж монгол хаадаас “олон шашныг зэргээр байлгах” гэсэн зорилго нь эвдэгдэж исламын шашин нь баруун хязгаарын эл газраар тархан дэлгэрэх боломжийг олгосон байжээ. Жэ-жэн-гийн 7 онд (1347) Цагаадай хаант улс хагацан задарч Тэнгэр уулын хойд хэсэгт Зүүн Цагаадай хаант улсыг байгуулсан Доголон Төмөр хаан исламын шашныг дэлгэрүүлэгчийн ятгал дор исламын шашинд орж түүний нөлөөллөөр хараат ард 16 түмэн монгол мусальман болов²⁹. Энэ ажиллагаанд исламын шашин Тэнгэр уулын ар өврөөрхи бүх нутагт ноёрхох байрыг эзлэхэд суурь тавьж өгчээ.

5. Доголон Төмөрөөс хойшхи Зүүн Цагаадай улсын Хэдэрхуж, Махму зэрэг хаад Турпань, Хамил зэрэг газар удаа дараалан олон удаа “ариун дайн” үүсгэж тэндэх уйгар иргэдийн исламжих явцыг ихээр түргэтгэсэн юм. Вась хааны үе болоход Турпань нэгэнт исламын шашны захирлын орон болжээ. Чин-хуа-гийн 9 оноос (1473) эхлэн Зүүн Цагаадай хаант улсын Енос хаан цэрэг хөдөлгөн Хамилийг эзлэн авснаас хойш хагас зуун жилийн турш Мин улстай тэмцээн хийж байгаад Хамилыг бүрэн эрхшээлдээ оруулан авч тус газрын бурхан шашны мужуудаар шүтэгч нэг хэсэг уйгар хүмүүс нь зүүнш Ганьсу зүг зугтаснаас бусад нь бүр исламын шашинд оров³⁰. Энэ мэтээр XVI зуун болох үест исламын шашин Тэнгэр уулын ар өврийн бүхий л нутаг дэвсгэр дээр ноёрхох байрыг эзэлж уйгарчуудын исламжих явц их төлөв биелэгдсэн байна. Мөн ч Тэнгэр уулын ар өврөөрхи турк хэлтний олон овог аймгууд исламын шашны захиргаан дор нягтран нэгдэж нэгдсэн уйгар үндэстэн болон бүрэлдэн тогтсон байна. Энэ нь монгол хаад ноёд өөрсдөө исламжихаар барахгүй баруунаас зүүнш исламын шашныг хүчээр дэлгэрүүлэн сурталчилсантай нягт холбоотой гэж баттай хэлж болно.

Хураангуйлбал, монголчууд хийгээд тэдний хойч үеийнхэн баруун хязгаарыг эзлэн захирч байсан үе бол одоогийн Шинжаний эл цөөн тоот үндэстэн бүрэлдэн

тогтсон цаг үе болно. Уйгар, хасаг, киргиз, хотон зэрэг эртний түүх соёлтой угсаатнууд урт удаан хугацааны нийлэлт, холилдолтоор дамжин энэ үед орчин үеийн үндэстний төрх төлөвийг бүрэлдүүлж чадсан байна. Мөн энэ үед исламын шашин Тэнгэр уулын ар өврийн үндэстнүүдийн шүтэн бишрэх цорын ганц шашин болж баруун хязгаарыг мянга гаруй жил ноёрхсон бурхан шашин, түүхийн үлдэгдэл болон хоцорсон байна. Мөн ч энэ үед баруун хязгаарын турк хэлтнүүдийн соёл урлаг хөгжин мандаж Цагаадай хэл, перс хэл, араб хэл болон уйгар хэлээр бичигдсэн утга зохиол, хэл, түүх, шүлэг дуулалын бүтээлүүд од мичид мэт олон гарч баруун Ляо улсаас эхлэн хэдэн зуун жил доройтож байсан байдлыг эцэслүүлж баруун хязгаарын соёл урлагийн сэргэн мандалтыг эхлүүлсэн байна³¹. Энэ үе нь мөн ч эртний баруун хязгаар болон Жун-Ян орны харьцааны түүхэн дээрх чухал цаг үе болно. Монгол хаад ноёд баруун хязгаараас дотор газар нэвтрэн ордог зам хоолойг "алтан зам" хэмээн хамгаалж хоёр газрын харьцаа холбоог үргэлжийн чанартай нягт байлгасан байна. Иймэрхүү олон шалтгаанаас монгол баруун хязгаарыг эзлэн захирч байсан түүхийг судлах нь туйлын чухал ач холбогдолтой юм.

Зүүлт тайлбар

¹ Жувиний «Дэлхийг эзэрхэгчийн түүх». Хятад хэвлэл. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. 1983 он. 45-46-р тал

² Чэн-Чэн, Ли-Шэн. «Баруун хязгаарын олон улсын түүх». (Улсаас эрхэлсэн Бэ-Пин номын сангийн тулгуур бичгийн цуврал)

³ Доссаны найруулсан «Монголд айлчилсан тэмдэглэл». Хятад хэвлэл. Хятад улсын Нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн хороо. 1983 он. 8-р тал

⁴ Мирзан Махаму Хайдар. «Рашидын түүх». Хятад хэвлэл. II боть. Шинжаны ардын хэвлэлийн хороо. 1983 он. 422-р тал

⁵ Доссаны найруулсан «Монголд айлчилсан тэмдэглэл». Хятад хэвлэл. Хятад улсын Нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн хороо. 1983 он. 113, 121-р тал

⁶ Мирзан Махаму Хайдар. «Рашидын түүх». Хятад хэвлэл. II боть. Шинжаны ардын хэвлэлийн хороо. 1983 он. 141-р тал

⁷ «Юан улсын түүх». 85-р боть. "Олон ноёдын шастир"-ын 1-д лавла.

⁸ Клек «Юан улсын үе дэх уйгарун түүхэн дурсгалт бичгийн удиртгал». Англи хэвлэл. Полминтун. 1975. VI бүлэг.

⁹ Ху-сэ-хуй. «Унд хоолны чухал зүйл» (Yin Shan zheng yao). II боть. "Будаа хоногийн төрөл, архи".

¹⁰ Фэн-Жүй «Юан улсын үеийн үзмийн дарс нэрэх мэргэжил хийгээд гардаг орон» "Хятад улсын түүх газарзүйн судлал". 1993 оны 3-р хугацааг лавламу.

¹¹ «Марко Пологийн аяллын тэмдэглэл». Хятад хэвлэл. Фү-Жэний шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо. 1981 он. 42-р тал

¹² Идагу гэгч бол уйгарын хаант улсын эзэн хаан болно.

¹³ Фэн-Жа-Байн «Гао-чань уйгар хаант улсын амьдрал». Хятад хэвлэл. 1988 он. 84-р тал

¹⁴ «Марко Пологийн аяллын тэмдэглэл». Хятад хэвлэл. Фү-Жэний шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо. 1981 он. 45-46-р тал

¹⁵ Доссаны найруулсан «Монголд айлчилсан тэмдэглэл». Хятад хэвлэл. Хятад улсын Нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн хороо. 1983 он. 156-р тал

¹⁶ Хуан-Ши-Жэнь «Юаны үеийн ёс заншил». "Юаны түүх ба умардын үндэстний түүхийн судлалын эмхэтгэл" –ийн 1987 оны 11-р хугацааг лавламу.

¹⁷ Хар хаант улс гэдэг нь он тооллын IX-XIII зууны үед оршиж байсан Тармын хотгороос баруун тийш Памирын Өндөрлөгөөс хойш газар нутаг түрэг хэлтнүүдийн байгуулсан ислам шашин шүтлэгтэй феодалын вант улс юм.

¹⁸ Рашид-Ад-Дин. «Судрын чуулган». Хятад хэвлэл. I боть. I дэвтэр. Шань-У ном хэвлэх газар. 1983 он. 247-р тал

¹⁹ Жувиний «Дэлхийг эзэрхэгчийн түүх». Хятад хэвлэл. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. 1983 он. 88-р тал

²⁰ Чэн-Чэн, Ли-Шэн. «Баруун хязгаарын олон улсын түүх». (1931 оны Шанхайгийн Шань-У дармал дэвтэр)

²¹ Ли-Жи-Чань. «Чань Чун бумбын баруунш зорчсон тэмдэглэл». 1988 он. 76-р тал

²² Хан-Ру-Линь. «Юаны үеийн киргиз болон түүний зэргэлдээ үндэстнүүд». "Юаны түүх ба умардын

- үндэстний түүхийн судлалын эмхэтгэл” –ийн 1987 оны 9-р бетиос лавламу.
- ²³ «Юан улсын түүх» 177-р боть. “Ли Ху Лигийн намтар”
- ²⁴ «Юан улсын түүх» 17-р боть. “Ши Зугийн намтар 14”
- ²⁵ «Юан улсын түүх» 128-р боть. “Тогтохын намтар”
- ²⁶ «Юан улсын түүх» 63-р боть. “Газарзүйн түүх: баруун хойдын газрын дагалдуулсан тэмдэглэл”
- ²⁷ Абу Хачи «Туркийн удам угсаа». Франц хэлний дэвтэрийн 166-р тал. « Хятад улсын Шинжаны эртний нийгэм амьдралын түүх» номоос дам ишлэв
- ²⁸ Мирзан Махаму Хайдар. «Рашидын түүх». Хятад хэвлэл. I боть. Шинжаны ардын хэвлэлийн хороо. 1972 он. 164-165-р тал
- ²⁹ Тен-Вэй-Жан «Исламын шашин Зүүн Цагаадай хаант улсад дэлгэрэн хөгжсөн тухай туршин өгүүлэх нь». “Үндэстний судлал”-ийн 1990 оны 5-р хугацааг лавламу
- ³⁰ Тен-Вэй-Жан «Шинжаны түүх судлалд Зүүн Цагаадай хаант улсын түүх эзлэх байр суурь хийгээд утга агуулга». “Шинжаны нийгмийн шинжлэх ухааны онолын тавцан” 1990 оны 3-р хугацааг лавламу.

Summary

J.Namkamyadag

The history and culture of the nationals of western China

This paper studies the influence that Mongolia had after it had dominated the West Boarder Provincial /XI YU/ where the politics, economy, culture and structure of nationalities were affected.

Because of the Mongolia rule that had dominated the West Boarder Provincial /XI YU/ the feudal separatist rule was ended and they had to give control over this area to those within the united state. So the economy developed and Islam was popularized. The above shows how the conditions under which the united Uigur nationality was formed.